



*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын
ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл*

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО ЧИГЛЭЛ

ТЗА-ны дарга Л.ХИШИГДУЛАМ

2017.05.12

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ
БИЧИГ ГЭЖ**

Зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрлийн талаар баримтлах зохицуулалтын бодлого чиглэлийг олон нийтэд ил тод болгох зорилгоор боловсруулсан.

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ
БИЧГИЙН ЗОРИЛГО**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн этгээдэд ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДЛУУД

Тусгай зөвшөөрлийн бодлого, чиглэл нь хот, суурины ус хангамж, ариутгах татуургын талаар төрөөс баримтлах бодлого, хөгжлийн стратегитэй уялдсан байна.

Усны үйлчилгээний салбарын үр ашгийг сайжруулах, өртөг зардлыг бууруулах, хэрэглэгчийн үйлчилгээг шинэ шатанд гаргах чиглэлд шинэ дэвшилтэт техник, технологи, ухаалаг систем нэвтрүүлэхийг дэмжинэ.

Үйл ажиллагааны үр ашгийг дэмжих, усны зүй зохистой хэрэглээ, усны зүй бус алдагдлыг бууруулах төрийн бодлоготой уялдсан зохицуулалтын орчинг бүрдүүлнэ.

Саарал усыг ашиглах болон гадаргын ус ашиглахыг дэмжих чиглэл баримтална.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн техникийн найдвартай байдал, үр ашиг, үйлчилгээний түвшинг сайжруулах, тэдгээрийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

Тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжид ил тод нээлттэй, шуурхай болгоход мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлнэ.

Нийслэл, орон нутагт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, техник, эдийн засгийн өндөр чадамжтай, цөөн тооны тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй болох чиглэл баримтална.

**ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХОД
БАРИМТЛАХ
СУУРЬ
ЗАРЧМУУД**

Техникийн хувьд найдвартай, аюулгүй, үр ашигтай горимыг хангасан байх,

Усны зүй зохистой хэрэглээг дэмжих, орлого болоогүй усны хэмжээг бууруулсан байх,

Ус хангамж, ариутгах татуургын ажил үйлчилгээ нь алдагдалгүй байх;

Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн дэглэмийг сахисан байх,

Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулах техникийн, хүний нөөц, санхүүгийн чадавхтай байх,

Аливаа хэлбэрийн татаас, санхүүжилтээр хэрэгжих төслийн хувьд санхүүжилтын орчин нь тодорхой, баталгаажсан байх,

Үйлчилгээ нь хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан байх,

**ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧДИЙГ
ҮНЭЛЭХ
ҮНЭЛЭМЖ**

Ус хангамж, ариутгах татуургын ажил үйлчилгээ нь тогтвортой, найдвартай, үр ашигтай ажиллах нөхцөл бүрдсэн байх,

Хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, стандарт дээшилсэн байх,

Тусгай зөвшөөрөл эзэмшигч бусад бизнес эрхлэгчийн эрх ашгийг хохироохгүй байх,

Дангаар ноёрхох асуудлаас сэргийлэхэд чиглэгдсэн байх,

Шинэ техник технологи нэвтрүүлсэн, үйл ажиллагаа нь тогтвортой байх.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагаар уг үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж ажиллах шаардлагуудыг тогтооно.

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн техник, эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүд, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, чанаржуулах бодит хөшүүрэг болж байх.

Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг жил бүр дүгнэх, шаардлагатай нөхцөл, шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтооно.

**ТУСГАЙЛСАН
ЗОХИЦУУЛАЛТЫН
ЧИГЛЭЛ, ЗАРЧИМ**

Ус хангамж, ариутгах татуургын ажил үйлчилгээ нь эдийн засгийн хувьд үр ашигтай, сард борлуулж буй усны хэмжээ нь үйл ажиллагаагаа хэвийн, алдагдалгүй явуулах нөхцлийг хангасан байх,

Цэвэрлэх байгууламж нь азот, фосфорын нэгдлүүдийг зайлуулах болон лагийг боловсруулах технологийн дамжлагатай, цэвэрлэгдээд гарч байгаа усыг нь саарал усаар ашиглах боломжтой байх,

Бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ нь тухайн нутаг дэвсгэрт байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийг хангасан байх,

**Зохицуулалтын
баримт бичиг,
дүрэм, журам**

Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журам

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг үнэлэх журам

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг
зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм

Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн шугам
сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох
журам

Дүгнэлт

1. Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын баримт бичгийг мөрдөж ажилласнаар Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ нь тогтвортой, найдвартай, үр ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.
2. Хэрэглэгчдэд хүрэх үйлчилгээний чанар, стандартыг дээшлүүлснээр хэрэглэгчдийн санал гомдлыг шуурхай барагдуулах, хэрэглэгчдийг ая тухтай амьдрах таатай орчинг бүрдүүлнэ.
3. Тусгай зөвшөөрөл олгосноор ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудыг суурь нөхцөл шаардлагаар дамжуулж чадавхыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх , олон улсын түвшинд үе шаттайгаар ойртуулах
4. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг аж ахуйн нэгж байгууллагад ил тод, нээлттэй байлгах, Тусгай зөвшөөрөл олгох үе шат дамжлагыг цөөлөх зэрэг бодлогыг баримтлан ажиллаж байна.